



НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын  
72 дугаар сургуулийн данс бүртгэлд  
хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 37,380,135 (гучин долоон сая гурван зуун наян мянга нэг зуун гучин тав) төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 72 дугаар сургууль (Б.Өнөржаргал)-д зөвшөөрсүгэй.


2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 72 дугаар сургууль (Б.Өнөржаргал)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.



ДАРГА М.БАЯРАА

11530700211



Бүртгэлд авах хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Нийслэлийн ерөнхий боловсролын 72 дугаар сургууль

/төгрөгөөр/

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Үйлдвэрлэсэн он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Хандивлагч байгууллага	
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	эх үүсвэр
1	Зөөврийн компьютер	HP	intel i58 8 gb8 HDD 500gb	2022	сайн	ш	15	2,492,009	37,380,135	Нийслэлийн Боловсролын газар, Сөүл хотын Боловсролын газрын хооронд хамтран ажиллах санамж бичиг	Буцалтгүй тусламж
Тоног төхөөрөмжийн дүн							15		37,380,135		
Нийт бүртгэх хөрөнгийн дүн							15		37,380,135		